



**“ЭКО КРЕДИТ ББСБ” ХХК –н Төлөөлөн Удирдах Зөвлөл /“ТУЗ”/-н
дэргэдэх эрсдэл, аудитын хорооны журам**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмаар ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны бүрэлдэхүүн, гишүүдийн бүрэн эрх, зохион байгуулалтын хэлбэр, чиг үүрэг, тогтоол шийдвэр, санал, дүгнэлт гаргах, холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх зэрэг үйл ажиллагаатай холбоотой холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Эрсдэл, аудитын хороо нь чиг үүргийнхээ хүрээнд тодорхой асуудлаар санал, дүгнэлт гарган ТУЗ-д таинлцуулах, хууль тогтоомжид заасан зарим асуудлаар шийдвэр гаргах эрхтэй байна.

ХОЁР. ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- 2.1 Эрсдэл, аудитын хороо нь хамгийн багадаа 3 гишүүнтэй байх ба ТУЗ нь Эрсдэл, аудитын хорооны гишүүд болон даргыг томилох бөгөөд хорооны гишүүдийн 2/3-оос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.
- 2.2 Эрсдэл аудитын хорооны дарга, гишүүдийн аль нэг нь санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэй байна.
- 2.3 Эрсдэл, аудитын хороо нь ТУЗ-д ажлаа танилцуулж, тайлагнана.

ГУРАВ. ХОРООНЫ ХУРАЛ

- 3.1 Эрсдэл, аудитын хороо нь жилд 4 хүртэл удаа, хамгийн багадаа жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан гарахаас өмнө 2 удаа хуралдсан байна.
- 3.2 Хурал нь хуралдааны болон эчнээ, цахим хэлбэрээр байх бөгөөд хурлын зарыг хуанлийн 7 хоногийн өмнөөс мэдэгдэж, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээ, тайланг гишүүдэд урьдчилан хүргүүлнэ.
- 3.3 Хуралд гишүүдийн 2/3 нь оролцсоноор хүчин төгөлдөр болох бөгөөд бусад этгээд оролцохгүй. Шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлага хорооны урилгаар оролцож болно.
- 3.4 Хурлыг хорооны дарга удирдаж, нарийн бичгийн дарга зохион байгуулна.
- 3.5 Хорооны хурлын хэлэлцэх асуудлыг хорооны дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нар хариуцан оруулна.
- 3.6 Хурлаар гарах бүх шийдвэрийг олонхын саналаар батална. Санал тэнцсэн тохиолдолд Эрсдэл, аудитын хорооны дарга хагалах эрхтэй.

ДӨРӨВ. ЭРСДЭЛ АУДИТЫН ХОРООНЫ ЭРХ

- 4.1 Эрсдэл, аудитын хорооны гишүүд нь дараах бүрэн эрхтэй байна. Үүнд:
 - 4.1.1 Санхүүгийн тайлангийн явцыг хянах;
 - 4.1.2 Албан үүргийнхээ дагуу шалгалт явуулах;
 - 4.1.3 Компанийн аудиторыг томилох, цалин урамшууллын хэмжээг тогтоох, тодорхой асуудлаар хяналт шалгалт хийх, ажлын гүйцэтгэлийг үнэлэх;
 - 4.1.4 Шаардлагатай үед ТУЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахыг шаардах, түүгээр хэлэлцэх асуудлыг санал болгох, дотоод хяналтын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, шаардлагатай үед гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг түдгэлзүүлэх.





ТАВ. ЭРСДЭЛ АУДИТЫН ХОРООНЫ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 5.1 Эрсдэл, аудитын хороо нь компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны бүхий л хүрээг хамрах хяналтын тогтолцоох бүрдүүлэх бөгөөд хяналтын тогтолцоо нь чадварлаг хараат бус, компанийн зохистой үйл ажиллагаа, үр ашгийг нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах, түүний эрсдэлээс сэргийлж чаддаг байна.
- 5.2 Эрсдэл, аудитын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна. Үүнд:
- 5.2.1 Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх;
 - 5.2.2 Санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих, онцгой анхаарал хандуулж ажиллах;
 - 5.2.3 Хөндлөнгийн аудитыг зохих ёсоор гүйцэтгэсэн эсэх;
 - 5.2.4 Санхүүгийн удирдлага зохистой эсэх, хийгдэж байгаа гэрээ хэлцэл их хэмжээний сонирхлын зөрчилтэй хэлцэл болох эсэх;
 - 5.2.5 Дотоод хяналтын үйл ажиллагаа зохистой байгаа эсэх;
 - 5.2.6 Мэдээлэл нээлттэй, ил тод байдал хангагдаж байгаа эсэх, гадагш мэдээлж байгаа мэдээллийн үнэн зөв байдал, компанийн нууцлал болон дотоод мэдээлэл алдагдсан эсэх, түүнийг буруугаар ашигласан эсэх.
 - 5.2.7 Хууль тогтоомжид заасан, эсвэл ТУЗ-өөс тодорхойлсон бусад асуудлаар дүгнэлт гаргах.

ЗУРГАА. АЖЛЫН ТАЙЛАН

- 6.1 Хорооны нарийн бичгийн дарга нь Эрсдэл, аудитын хорооны хурлын батлагдсан тэмдэглэлийг ТУЗ-ийн бүх гишүүд, дотоод, гадад аудит болон гүйцэтгэх удирдлагад хүргэнэ. Тэмдэглэлд хурлаар хэлэлцсэн чухал санал, дүгнэлт, тохиролцсон асуудлыг багтаасан байна.
- 6.2 Эрсдэл, аудитын хороо нь албан үүргийнхээ хүрээнд гүйцэтгэх чиг үүрэг, хариуцлагын дагуу хийсэн ажлаа жил бүр ТУЗ-д тайлагнана.

ДОЛОО. ЖУРАМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

- 7.1 Хороо нь энэхүү журмын заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн хуралд санал оруулж шинэчлэн баталж болно.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

